



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

БАТЛАВ,  
САЛБАРЫН УЛСЫН  
ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

/Албан тушаал/



А.ЭНХМАНЛАЙ

/Гарын үсгийн тайлал/

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УДИРДАМЖ

2026 оны 02 дугаар сарын 26

Дугаар 35-00/03

Улаанбаатар хот

Г Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай Г

Нэг.Шалгалтын зорилго, шалгалтын үндэслэл

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>3</sup> дугаар зүйл, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл болон газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай, Зөвшөөрлийн тухай, Газрын тухай, Геодези, зураг зүйн тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм, норматив, дүрэм, журам, стандарт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын хэрэгжилтийг шалгаж, үнэлгээ дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх замаар болзошгүй аюул эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсооход оршино.

Хоёр.Шалгалтад хамрагдах асуудал, хүн хуулийн этгээд, объектын нэр

Шалгалтад хяналт шалгалтын чиглэлээр дараах асуудлуудыг хамруулна.

Үүнд:

2.1.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд:

- 35.5 кодтой "Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар;

- Мэргэжлийн боловсон хүчин болон суурь, нөхцөл шаардлага хангаж буй эсэх;

- Хэмжлийн багажинд баталгаажуулалт хийгдсэн эсэх;

- Улсын болон орон нутгийн төсөв, төрийн байгууллага хэрэгжүүлж байгаа төслийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геодезийн хэмжилт, зураглалын ажлыг солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоо, нарийвчлал, стандарт, техникийн шаардлагад

1535080006

нийцүүлсэн эсэх;

- Бүх төрлийн геодезийн хэмжилт, зураглалын ажлыг солбицол, өндрийн нэгдсэн тогтолцоо, нарийвчлал, стандарт, техникийн шаардлагад нийцүүлсэн эсэх;

- Гэрээний үүргийн биелэлт;

2.2.Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхтэй хуулийн этгээдийн үйл ажиллагаанд:

- Суурь, нөхцөл шаардлага хангаж буй байдал (хүний нөөцийн мэдээлэл, ажлын байрны орчин нөхцөл);

- Бүх ангиллын кадастрын зургийг масштаб, байрлал, өндрийн нарийвчлалд хийсэн, техникийн шаардлага хангасан эсэх;

- Багаж хэрэгслийн бүрдэл;

- Мэргэжлийн байгууллагын эрх авахад байгуулсан гэрээний үүргийн биелэлт;

- Мэргэжлийн байгууллагуудын гүйцэтгэсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянан үзэх; (Хавсралт 1-т заасан маягтын дагуу хянаж үзнэ)

Гурав. Шалгалтын төрөл

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хэлбэрээр зохион байгуулна.

Дөрөв. Шалгалтын арга

4.1.Хяналт шалгалтыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолоор батлагдсан “Хяналт шалгалт хийх нийтлэг журам” болон эрх зүйн бусад баримт бичгийн хүрээнд хийж гүйцэтгэнэ.

4.2.Улсын (ахлах) байцаагч нь иргэн, хуулийн этгээдийн хяналт шалгалтад хамрагдах объектын холбогдох баримт бичгийг судалж танилцах, мэдээлэлтэй танилцаж хянан үзэх, тайлбар авах, ажлын байранд үзлэг хийж, баримт бичгийг хуулбарлан баталгаажуулах, шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны байгууллагуудад хадгалагдаж байгаа баримт бичгүүдийг гаргуулж авах, тулгаж үзэх, хувилж авах, хяналтын хуудсаар эрсдлийг үнэлэн, шалгуулагч этгээдийн хууль тогтоомж, норм, стандартын сахин мөрдөлтийн түвшинг тогтоож, хяналт шалгалтын явцад болон илэрсэн зөрчил, дутагдлыг баримтжуулан фото зураг авах зэрэг аргуудаар хийж гүйцэтгэнэ.

4.3.Хяналт шалгалт хийхдээ шаардлагатай баримт бичиг, холбогдох судалгаа, мэдээллийг шалгуулагч этгээдийн эрх бүхий албан тушаалтнаар гарын үсэг зуруулан хүлээн авч, шалгалт дууссаны дараа албан ёсоор хүлээлгэж өгнө. Шаардлагатай бол нотлох баримт болгохоор хувилуулж авна.

Тав.Шалгалт хийх бүрэлдэхүүн

5.1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын Салбарын хяналт шалгалтын хэлтсийн газар, геодези зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчид;

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

7.1. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын нэгдсэн дүнг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллана.

\_\_оОо\_\_

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ТАЙЛАН,  
ДҮГНЭЛТИЙГ ХЯНАН ҮЗЭХ МАЯГТ

Хянан баталгааны тайлан, дүгнэлтийг батлагдсан аргачлалын дагуу хийсэн эсэх <b>(5 оноо)</b>	Тайлан нь агуулгын дагуу, монгол хэл бичгийн зөв бичих дүрмийг баримтлан, утга найруулгын алдаагүй, батлагдсан аргачлалын дагуу хийгдсэн эсэх;	
	<i>Туйм: 5</i>	<i>Үгүй: 0</i>
Хянан баталгааны цэгийн бүрдүүлэлт <b>(5 оноо)</b>	Хөрсний дээж, ургамлын бичиглэл, усны дээжийг арга зүйн дагуу авч зургаар баталгаажуулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 5</i>	<i>Үгүй: 0</i>
Сүлжээний зургийн боловсруулалт <b>(5 оноо)</b>	Кадастрын цэгийн солбицол, хөрсний механик бүрэлдэхүүн, хөрсний хими шинж чанар, хөрсөн дэх хүнд металын агууламж, хөрсний эрүүл ахуй, ургамлын бичиглэл, усны шинжилгээний үзүүлэлтийг оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Зургийн нэрийг өгөхдөө Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код (ММ85641 -0-20068 2х, ММ85641-1- 2006 6х, МН85641-2-2006 34х, М^85641-3-2006 47х) стандартыг ашигласан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Зурагт газар зүйн солбицлын тор оруулсан эсэхийг хянасан байдал	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Газар ашиглалтыг бүрэн гүйцэт зурагласан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Агаар сансрын зураг оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
Давхаргын мэдээлэл бүрдүүлэлт <b>(5 оноо)</b>	Нийт эзэмшил газрын талбайн оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Нэгж талбарын талбайг оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Газар дээрээ ашиглаж байгаа талбайг оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
	Үйл ажиллагаанд өртөөгүй (зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй) талбайг оруулсан эсэхийг хянасан байдал;	
	<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>
Үйл ажиллагаанд өртсөн (зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй) талбайг оруулсан эсэхийг хянасан байдал;		
<i>Туйм: 1</i>	<i>Үгүй: 0</i>	

<p>Хянан баталгааны дүгнэлт, зөвлөмжийн боловсруулалт <b>(10 оноо)</b></p>	<p>Газрын хэмжээ, нэгж талбарын тоо, газар ашиглалтын онцлог, газрын гадарга, хөрс, ургамлын төлөв байдал, чанар, түүний өөрчлөлт, нөлөөлж байгаа шалтгаан хүчин зүйл, сөрөг үр дагавруудыг арилгах, газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хамгаалах талаар үндэслэлтэй зөвлөмж өгсөн эсэхийг хянасан байдал;</p>	
	<i>Тийм: 5</i>	<i>Үгүй: 0</i>
	<p>Зөвлөмж нь тухайн нэгж талбарын байгаль цаг уурын онцлог, хөрс, ургамал, газар ашиглалтын аюулгүй байдалд ерөнхий дүгнэлт өгсний үндсэн дээр сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар үндэслэлтэй тусгасан эсэхийг хянасан байдал;</p>	
	<i>Тийм: 5</i>	<i>Үгүй: 0</i>